



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/609

Улаанбаатар хот

Морин хуурын олон улсын ҮИ наадам  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.5, 2017 оны 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох” зорилтын хүрээнд “Морин хуурын олон улсын ҮИ наадам”-ыг 2018 оны 06 дугаар сарын 30-наас 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд өндөр хэмжээнд зохион байгуулахыг Нийслэлийн Соёл, урлагийн газар /Ж.Дамдинцэрэн/-т даалгасугай.

2. “Морин хуурын олон улсын ҮИ наадам”-ыг зохион байгуулахад шаардагдах, энэ захирамжийн хавсралтаар баталсан 53,198,500 /тавин гурван сая нэг зуун ерэн найман мянга таван зуун/ төгрөгийг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал”-аас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2018 оны  
07 дугаар сарын 08 -ны өдрийн  
Х/609-р захирамжийн хэвсрэлт

"МОРИН ХУУРЫН ОЛОН УЛСЫН VI НААДАМ" – УРАЛДААН 2018"-ЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Хянасан
<b>Нэг. Морин хуур сонирхогчдын уралдаан</b>						
Шагналын сан						
1	1-р байр	хүн	1	1 000 000	1 000 000	1 000 000
	2-р байр	хүн	1	800 000	800 000	800 000
	3-р байр	хүн	1	500 000	500 000	500 000
2	Шүүгчдийн урамшуулал	хүн/өдөр	5/2	170 000	1 700 000	1 000 000
3	Цом хийлгэх зардал	ширхэг	1	54 000	54 000	54 000
4	Цай, кофе, ус	өдөр	2	30 000	60 000	-
5	Анонс /тайз/	м <sup>2</sup>	24	6 000	144 000	144 000
6	Хөлтэй самбар	ширхэг	16	45 000	720 000	320 000
7	Танилцуулга /ном/	ширхэг	300	3500	1050 000	1 050 000
<b>Дүн</b>					<b>6 028 000</b>	<b>4 868 000</b>
<b>Хоёр. Мэргэжлийн морин хуур урлаачдын уралдаан</b>						
Шагналын сан						
1	1-р байр	хүн	1	2 000 000	2 000 000	2 000 000
	2-р байр	хүн	1	1 500 000	1 500 000	1 500 000
	3-р байр	хүн	1	1 000 000	1 000 000	1 000 000
2	Шүүгчдийн урамшуулал	хүн/өдөр	5/2	170 000	1 360 000	1 000 000
3	Цом	ширхэг	1	53 000	53 000	53 000
4	Баннер /тайз/	ширхэг	24мх1	6 000	144 000	144 000
5	Хаалт самбарын түрээс	Өдөр	2	300 000	600 000	600 000
<b>Дүн</b>					<b>6 657 000</b>	<b>6 297 000</b>
<b>Гурав. Нээлтийн арга хэмжээний зардал</b>						
1	Баннер / даавуун/	ширхэг	32м <sup>2</sup>	18 000	576 000	576 000
2	Хөтлөгч	Хүн/өдөр	1/1	1 000 000	1 000 000	800 000
3	Тайзны зураач, тайз чимэглэл түрээс	хүн	1	2 500 000	2 500 000	2 500 000
4	Нээлтийн арга хэмжээний тайзны түрээс /Соёлын төв өргөө/	Цаг/өдөр	2/1	3 000 000	3 000 000	3 000 000
<b>Дүн</b>					<b>7 076 000</b>	<b>6 876 000</b>
<b>Дөрөв. Хаалтын арга хэмжээний зардал</b>						
1	Генератор түрээс		1	10 800 000	10 800 000	10 800 000
	Тайзны нэмэлт хэл карказны түрээс			1 100 000	1 100 000	1 100 000
2	Тайзны нэмэлт карказны гэрэлний түрээс			1 100 000	1 100 000	1 100 000
	Нэгдсэн тайзны уран бүтээлчдийн асар	ш/өдөр	20/6	80 000	9 600 000	9 600 000
3	Нэгдсэн тайзны пульт байрлах асар	ш/өдөр	2/12	80 000	1 920 000	1 920 000
4	Хөтлөгч	Хүн/өдөр	2 / 1	1 000 000	1 000 000	800 000
5	Найруулагчийн урамшуулал	Хүн/өдөр	1 / 1	1 500 000	1 500 000	1 000 000
6	ЛЕД дэлгэцний дүрс				2 000 000	2 000 000

	бэлтгэх					
7	Мандат /Хэвлэл, Гэр, Хэвлэлтэй тууз/	Ширхэг	150	3 750	562 500	562 500
8	Постер хэвлэл /А3/	Ширхэг	100	1 000	100 000	100 000
9	Урилга	Ширхэг	500	1100	550 000	550 000
10	Дугтуй	Ширхэг	500	300	150 000	150 000
11	Зочдын энгэрийн зүүлт	Ширхэг	30	2500	75 000	75 000
12	Самбарын түрээс /ГХЯ-ны дэргэдэх анонс өлгөх/	хоног	14	200 000	2 800 000	2 800 000
13	ТВ шторк	Ширхэг	2	300 000	600 000	600 000
14	Баримтат нэвтрүүлэг	Ширхэг	1	2 000 0000	2 000 000	2 000 000
				<b>Дүн</b>	<b>35 857 500</b>	<b>35 157 500</b>
				<b>Нийт дүн</b>	<b>55 618 500</b>	<b>53 198 500</b>